

Гурван монгол үсгийн гурван гийгүүлэгч
(Соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра үсгийн жишээгээр)

АЛИНЗУЛ*

БНХАУ-ын ӨМӨЗО, Хөх хот,

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургууль

Received: 30 August 2025 / Accepted: 17 September 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Монголчууд түүхийн урт удаан цаг хугацааны туршид олон зүйл үсэг бичгийг зохион хэрэглэж ирсэн баялаг уламжлалтай ард түмэн. Тэдгээрийг дотоод гадаадын эрдэмтэд тасралтгүй судлан шинжилсээр байгаа билээ. Олон үсэг бичгийн тус тусын судалгаа харьцангуй сайн хийгдсэн боловч соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра гэх гурван монгол бичгийн үсэг зүйг харьцуулан судалсан судалгаа хараахан гараагүй гэж болно. Тус өгүүлэлд *n*, *ng*, *ñ* гэх гурван гийгүүлэгч үсгийг гурван монгол бичигт тэмдэглэсэн байдлыг шинжлэх, улмаар, *n*, *ng* хоёр гийгүүлэгч монгол хэлний авианы хөгжлийн явцад хоорондоо зохих тогтолцоонд харилцан солигдож байгаа байдал, жич гурван монгол үсгээр тагнайшсан *n* гийгүүлэгчийг тэмдэглэсэн шинэ үсэг зүйн үзэгдлийг онцлон тодорхойлохыг зорив.

Түлхүүр үгс: Соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра, монгол үсэг, *n*, *ng*, *ñ* гурван гийгүүлэгч

The Three Consonants of Three Mongolian Scripts
(By the Example of the Characters Soyombo, Horizontal Quadratic, and Vagindra)

ALINZUL

Institute of Mongolian Studies, Inner Mongolian University,

Hohhot, Inner Mongolia, China

Abstract: Mongolians have created and used different scripts at different historical periods. They are continuously studied and analyzed by domestic and foreign scholars. Although many scripts have been studied individually, there is no comparative study of the three Mongolian scripts, namely soyombo, horizontal quadratic and vagindra. This paper aims to analyze the writing of the three consonants *n*, *ng*, and *ñ* in the three Mongolian scripts, and to highlight the situation in which the two consonants *n* and *ng* alternated in the appropriate system during the development of the phonetics of the Mongolian language, as well as the new philological phenomenon of the nasalization of the consonant *n* marked in these three Mongolian scripts.

* © Алинзул, 2025, Email: alinzvl6@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

1. Удиртгал

Монголчууд түүхэндээ олон зүйлийн үсэг бичгийг зохион хэрэглэж ирсэн билээ. Үүнд уйгуржин монгол үсэг, Пагва ламын дөрвөлжин үсэг (1268), Аюуш гүүшийн али гали үсэг (1587), Ойрадын Зая бандида Намхайжамцын тод үсэг (1648), Өндөр гэгээн Занабазарын соёмбо үсэг ба хэвтээ дөрвөлжин үсэг (1686), Агваан лхаарамбын вагиндра үсэг (1905), кирилл үсэг (1946) зэрэг болно. Эдгээр үсэг бичиг нь хоорондоо нягт харьцаа холбоотой байдаг. Ялангуяа дөрвөлжин, соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра үсэг зэрэг нь энэтхэг төвөдийн үсгийн тогтолцоо, цагаан толгойн үсгийн дэс дарааг харгалзсан учир бие биедээ нөлөөлсөн зүйл их буй. Эл олон үсэг бичиг дотроос соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра үсэг хэмээх сүүлийн гурван зуу орчим жилд монгол хүний зохиосон гурван цагаан толгойноос гурван үсгийг тэмдэглэж хэрэглэсэн байдлыг онцлон хэлэлцье. Пагва ламын зохиосон дөрвөлжин үсгийн монгол хэлний дурсгалд **ñ** гийгүүлэгч одоогоор бидний олж үзсэн сурвалжийн хэмжээнд тохиолдсонгүй. Ийм учраас соёмбо, хэвтээ дөрвөлжин, вагиндра зэрэг гурван монгол бичгийн дурсгалын хэмжээнд авч үзсэн билээ. Дүрс тэмдгийн хувьд соёмбо нь ланз, төвөд, монгол бичгийн олон зурлагыг ашиглан бүтээсэн байдаг. Хэвтээ дөрвөлжин үсэг нь төвөдийн шар үсгээс эхтэй хэмээдэг. Вагиндра үсэг нь монгол бичгийн суурин дээр галиг үсэг, тод бичгээс санаа авсан нь тодорхой юм. Энэхүү гурван үсэг бичгийн хувьд ижил төстэй талууд оршиж байна. Гурван монгол бичгийн цагаан толгойн дараалал нь самгарди цагаан толгойн тав таваар нэг аймаг, төвөд цагаан толгойн дөрөв дөрвөөр нэг аймаг болгон жагсаадаг арга тогтолцооны дагуу монгол хэлний авианы онцлогт тохируулан цөм гурав гурваар нэг аймаглан жагсаасан байдаг. Мөн гурван монгол бичгийн цагаан толгой үсэгт **n, ng, ñ¹** гэсэн нэг төрлийн гурван гийгүүлэгч үсгийг тусгай тэмдгээр тус бүр бие даасан гийгүүлэгч үсгээр ялгаж тэмдэглэсэн бөгөөд бодитой хэрэглэсэн байдал нь ойролцоо байна. Гурван монгол бичгийн авианы нарийн тэмдэглэгээ нь XVII-XX зууны монгол хэлний халх, буриад аялгууг шинжилж мэдэхэд чухал судалгааны ач холбогдолтой билээ.

2. Судалгааны арга зүй

Өгүүлэлд Р.Отгонбаатар, А.Д.Цендина нарын “Монгол үсэг бичгийн дээж” (2014), Р.Бямбаагийн “Занабазарын дөрвөлжин үсэг” (2005), Соёлмаагийн “Вагиндара үсгийн сурвалж бичгийн судлал” (2017) зэрэг ном бүтээлд багтсан гурван монгол бичгийн дурсгалыг судалгааны голлох эх хэрэглэгдэхүүн болгосон бөгөөд чингэхдээ эх бичиг сурвалж судлалын үүднээс харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашигласан болно.

3. Гурван бичигт n ба ng гийгүүлэгчийг тэмдэглэсэн байдал

n гийгүүлэгч бол монгол хэл төдийгүй дэлхийн бараг бүх хэлэнд байдаг түгээмэл авиа, үсэг болно. Тиймээс түүнийг тэмдэглэсэн үсгийн тэмдэг бүх цагаан толгойн үсэгт бий. Харин түүнтэй холбоотой **ng, ñ** хоёр гийгүүлэгчийг тэмдэглэсэн үсэг монгол бичгийн цагаан толгойн жагсаалтад байдаггүй. Монгол бичгийн хэлний **ng** гийгүүлэгч нь эгшгээр амилдаггүй учир цагаан толгойн толгой үсэгт багтдаггүй уламжлалтай. **ñ** бол **n** гийгүүлэгчийн тагнайшиж дуудагддаг хувилбар бөгөөд монгол бичигт түүнийг тэмдэглэсэн үсгийн тэмдэг байхгүй. Бидний судлагдахуун болох гурван монгол бичгийн цагаан толгойд **ñ**-д тусгай үсгийн тэмдэг зохион тэмдэглэсэн бөгөөд **ñ, ng** хоёр гийгүүлэгч үсгийг цагаан толгойд багтаан жагсаасан өвөрмөц онцлогтой. Тэдгээр нь тус гурван монгол бичгийн дурсгалуудад идэвхтэй хэрэглэгджээ.


¹ Гурван гийгүүлэгчийн үсгийн галиг: n, ng, ñ, авианы галиг: [n], [ŋ], [nʰ].

Тэдгээрийн тэмдэглэгдэж хэрэглэсэн байдлаас монгол хэлний төв халх жич буриад аялгууны авианы хөгжил хувирал, шинэчлэлийг олж харж болно. Гурван гийгүүлэгчид холбогдох авианы судалгааны байдлыг анхаарч үзвэл, Өвөр Монголын эрдэмтэн Пэлжээ бээр “Монгол баримжаа авианы [ng] гийгүүлэгчийн асуудалд” гэх зохиолдоо монгол хэлний [n], [ŋ] авиалбарын тухай “[n] авиалбар нь (n) / (ŋ) / (m) гэх гурван хувилбартай, (ŋ) нь гол хувилбар болно, [ŋ] авиалбар нь (n) / (γ) / (m) гэх гурван хувилбартай” (1992:30) гэжээ. Үүнд [n], [ŋ] хоёр авиалбар нь цөм тус тусынхаа авиалбарын хувилбар болж байна. Ер нь аялгууг тэмдэглэсэн үсэг бичиг нь авиалбар ба хувилбарыг харьцангуй нарийн тэмдэглэж, тухайн аялгууныхаа бусад аялгуунаас ялгагдах онцлогийг илрүүлсэн байж таарна. Гурван монгол бичигт **n**, **ng**, **ñ** гурван гийгүүлэгчийг тэмдэглэсэн байдлыг монгол бичигтэй харьцуулан ажиглавал зөрөөтэй бичлэг нэлээд бий. Бид тэдгээрийн бичлэгийг нарийн шинжилж үзье.


3.1. Үгийн эцсийн ng гийгүүлэгч

Монгол бичигт үгийн эцэст орох **ng** гийгүүлэгчийг гурван монгол бичигт адилхан **ng** хэлбэрээр бичиж тэмдэглэсэн байна. Уйгуржин монгол бичгийн дурсгал "Чингисийн чулуун бичиг"-ээс "Бодичарьяавадара" жич түүний тайлбар ба "Тахимдуу бичиг" зэрэгт бичигдсэн **ng** төгсгөлтэй ‘eng, orčilang, sang, čing, amuyulang, jiryalang, jobalang, üjesküleng, bayasqulang, dügüreng, bursang, bulčing’ зэрэг хориод үг байдаг. Эдгээр үгээс гурван монгол бичгийн дурсгалд ‘amuyulang, jiryalang, jobalang, orčilang, dügüreng, sang’ гэх мэт үгс илэрсэн бөгөөд уламжлал ёсоор бичжээ.


Соёмбо.	a-mu-yu-lang (ge-gēn u-kān-nu ge-rel. 1b,2m) ²	Зураг 1.
	jir-ya-lang (itegel. 3e,1m)	Зураг 2.
Хэвтээ.	a-mu-yu-langtu- (амгалант тамага)	Зураг 3.
дөрвөлжин.	jir-ya-lang (живзүндамбагийн цадиг. 5a,4m)	Зураг 4.
Вагиндра.	amoyaolang (borqang bayšing namtar. 2x,3m)	Зураг 5.
	jaryalang (uqang xuryaži sedkel hayžirülqo huryalnūd orošiba 21x,17m)	




Зураг 1.



Зураг 2.




Зураг 3.



Зураг 4.



Зураг 5.



Зураг 6.

Дээр дурдсан уйгуржин бичгийн дурсгалуудад илэрсэн **ng** гийгүүлэгчтэй үгсэд үгийн дунд орсон **ng**-тэй үг 70 орчим бий. Олонх нь хэлний угийн **q/γ** гийгүүлэгчийн өмнө тохиолдсон байна. Монгол бичгийн хэлэнд тэмдэглэж байгаа язгуур үгийн дундах **ng** бол олонх нь хэлний угийн авианы өмнө тохиолдсон [n] авианы нөхцөлт хувилбар (ŋ) байж, хэлний угийн бус авианы өмнө орсныг **ng** гэж бичиж байвч түүнийг орчин үеийн авиа зүйн хуулиар [n] гэж дууддаг хэмээн өвөр монголын эрдэмтэн Авхан. Лутжаргал (1991) үзсэн байдаг.

Соёмбо бичгийн дурсгалд ‘önggö, tengri, mongyol, činggis, čingya’ гэх мэт жишээ үгс хэлний угийн гийгүүлэгчийн өмнө тохиолдсон **ng** гийгүүлэгчийг **ng** ба **n** хоёр хэлбэрээр бичжээ. Соёмбо үсэг нь монгол бичиг ба тухайн үеийн аман ярианы дагуу бичдэг байснаас энэхүү нэгдэлгүй бичлэг, тогтворгүй хоёр зүйлийн хэлбэрийг тэмдэглэж үлдээсэн бололтой. Аман

² Хаалтад жишээ үгийн илэрсэн дурсгалын нэр, хуудасны дугаар, мөрийн дугаарыг бичив.

ярианы дагуу бичсэн хэмээн сэтгэвээс хэлний угийн гийгүүлэгчийн өмнө [ŋ]-ээр дууддаг **ng**-д авианы хувиралт үүсэж байгааг ажиглан тэмдэглэсэн үү гэж үзмээр байна. Вагиндра үсгийн ‘jobalan-ha’ гэх жишээнд ч хэлний угийн гийгүүлэгчийн өмнө **n**-ээр бичсэн байдал харагдана.

3.2. Угийн эцсийн **n** гийгүүлэгч

Угийн эцсийн **n** гийгүүлэгчийг **ng**-ээр тэмдэглэсэн байна. Соёмбо бичгийн дурсгалд энэ байдал төдийлөн харагдахгүй ч цөөн жишээ бий. Х.Нямбуугийн “Монгол хувцасны түүх” (2002) номд Богд хаант Монгол улсын ноёд түшмэдийн ёслолын хувцасны зэрэг дэвийн фүс тэмдгийг нарийн танилцуулсан байдаг. Үүнд Жүн вангийн хүрэмний фүс нь ар, өвөр талдаа ‘Соёмбо Э-бам’ гэдэг алтан үсэг ба хоёр мөрөн дээрээ соёмбын ‘алтан наран саран’ хатгасан дугариг байдаг. Засаг тэргүүн тайжийн хүрэмний өмнө, хойтод соёмбын алтан наран, саран хатгасан дөрвөлжин фүс хаддаг байжээ. Монгол хэлээр соёмбо үсгээрх наран, саран нь нэг эгшигтэй үеүдийг угсруулан босоогоор зохиомжилсон байна. Бичмэл нь босоо соёмбын сонгодог жишээ болно. Монгол улсын эрдэмтэн Р.Отгонбаатар 2018 оны бүтээлдээ босоо соёмбын олон тодорхой жишээг дурдсан билээ. Наран, саран үсгийн дэвсгэр **n** гийгүүлэгчийг **ng** гийгүүлэгчээр бичсэн онцлогтой.

Соёмбо.	na-rang (Монгол хувцасны түүх. Р.363)	Зураг 7.
	sa-rang (Монгол хувцасны түүх. Р.363)	Зураг 8.



Зураг 7.



Зураг 8.

Эрдэмтэн Авхан. Лутжаргал “орчин цагийн монгол хэлний **n** төгсгөлтэй үгэнд тогтвортой тогтворгүй **n**-ээр төгссөн бүх жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний нэр хийгээд үйлт нэр жич нөхцөл үйлийн хам хэлбэр багтдаг” (1991:32) гэжээ. Хэвтээ дөрвөлжин ба вагиндра үсгийн дурсгалуудад **n** төгсгөлт үгийн эцсийн **n** гийгүүлэгчийг **ng**-ээр тэмдэглэсэн нь маш түгээмэл байна. Хоёр үсгийн дурсгалын жишээнүүдийг ангилж үзсэний дүнд дээрх томъёолол дахь **n** төгсгөлтэй үгстэй дүйцэж байна. Жишээлбэл, хэвтээ дөрвөлжин үсэгт ‘na-rang, bog-qang, o-lang, qo-yo-song, sāng, aγ-sang, bo-lay-sang, me-deng’, вагиндра үсэгт ‘narang, boraqang, olang, qōhong, hayng, bolhang, aγng, küseheng’ гэх мэт буй.

Цаашилбал үгийн эцсийн **n** гийгүүлэгч **ng**-ээр дуудагдах болсон талаар авиа зүй судлаачид олон зүйлийн болзол шалтгааныг дурдсан байдаг. Энд тэдгээр олон авианы нөлөөлөл хувирлын жам хуулийг дахин тодруулалгүй, харин тодорхой үсэг бичигт тодорхой үсгийн жишээн дэх хувиралтыг тэмдэглэснийг батлан харуулахыг зорив. Ер нь монгол хэлний эгшиг зохицох ёс бол өгүүлэх үеийн хүчдэлийг хэмнэх арга гэдэг. Дээрх авианы хувиралт нь ч авиаг аль болох саадгүй шулуун угсран хэлэх хөгжлийн жам дагуух хувьсал хэмээн бодно.

3.3. Зарим тийн ялгалын нөхцөл

Зарим тийн ялгалын нөхцөлийг **ng** хэлбэрээр хэвтээ дөрвөлжин ба вагиндра үсгийн дурсгалд бичиж тэмдэглэжээ. Харьяалахын тийн ялгалын ‘-yin,-un’, ерөнхийлөн хамаатуулах ‘-ben/-iyen’, сул үг ‘müng’ зэрэг. Хэвтээ дөрвөлжин дурсгалд ‘er-dem-müng, tü-bed-düng, mo-to-ri-yeng, müng’, вагиндра үсэгт ‘erdinīng, qoroüng, qoyūlang, müng’ гэх мэтийн **n** төгсгөлтэй тийн ялгалын нөхцөл ба сул үгийг **ng**-ээр бичиж байна.

4. Гурван бичигт **ñ** гийгүүлэгчийг тэмдэглэсэн байдал

Өмнөх монгол бичиг үсэгт огт тэмдэглээгүй **n** үсгийн нэгэн хувилбарыг гурван монгол бичгээр тэмдэглэсэн байна. Ер нь монгол бичигт тагнайшсан гийгүүлэгчийг тэмдэглэдэггүй. Соёмбо ба хэвтээ дөрвөлжин бичигт ганцхан **n** гийгүүлэгчийн тагнайшлыг үсгийн тэмдэг оноох аргаар тэмдэглэжээ. Харин вагиндра бичигт бол тагнайшсан гийгүүлэгч бүгдийн ард нь бинт тавьж тухайн гийгүүлэгчийн тагнайшлыг илэрхийлэг дүрэмтэй. Ялангуяа **n** гийгүүлэгчийн тагнайшлыг бинт тавьж тэмдэглэснээс гадна бас шинэ үсгийн тэмдэг оноон тэмдэглэсэн байдаг. Үүний тухай эрдэмтэн Соёлмаагийн хэвлүүлсэн “Вагиндра үсгийн сурвалж бичгийн судлал” бүтээлд гэрэл зургийн хэлбэрээр орсон Агваандоржийн бичсэн “Шинэ хуучин үсгүүдийн ялгал тэргүүтнийг бичсэн дэвтэр оршив” хэмээх вагиндра үсгийн дурсгалд “Хэрэв **n** үсэгт зөөлний тэмдэг тавивал **ñ** үсэг хэрэгтэй биш болбоос манай хэлэнд **ñ** үсэг олон хэлэгдэх тул **ñ** хэрэгтэй мэт болбоос мэргэдийн тааллаар болох мөн” (8-р тал)³ гэж **n** гийгүүлэгчийн тагнайшлыг ард нь бинт тавих ба шинэ **ñ** үсгээр илтгэн хэрэглэх хоёр аргийг тодорхойлжээ. Монгол хэлний **n** гийгүүлэгч голдуу өмнөх хойнох **i** эгшгийн нөлөөгөөр тагнайшдаг. Тагнайшсан хэмжээ нь олон монгол хэл аялгуунд харилцан адилгүй байдаг. Вагиндра үсгийн дурсгалд **ñ** гийгүүлэгчийн талаар онцлон тэмдэглэсэн нь буриад хэлэнд энэхүү тагнайших үзэгдэл илт мэдэгддэгтэй шууд холбоотой юм.

Соёмбо бичгийн дурсгал ховорхон учир **ñ** үсэг цөөн тохиолдож байна. Нэгэн содон жишээ бол Номгоны Дара эх лам Агваанчүлтэмжамцын төвөд хэлээр бичсэн “Найман Богдын намтар” (Агваанчүлтэмжамц, 1925)-ын эхэнд байх тахилын шүлгээ самгарди, төвөдөөс гадна соёмбо үсгээр монгол хэлээр бичжээ. (Зураг 9.)



Зураг 9. Соёмбо үсгээр

Тахилын шүлэг нь дөрвөн шад, хоёр мөр. Галиглан үзүүлбэл :

gur-ban ñiu-ča-un er-dem da-lai me-tü-ün san

gur-ban san-sar da-ki ya-bog-čid-ün yi-te-gel

gur-ban ra-dan-in mön čī-nar-tu bla-ma-yū-nān

gur-ban eu-den-ē-če-bēn bi-šīr-čiu mür-gū-mī. Тус шүлгийн эхний мөрийн хоёрдугаарт буй ‘нууц’ хэмээх үгийн эхний гийгүүлэгчийг соёмбо үсгийн **ñ**-аар ‘ñiu-ča’ гэж бичиж тэмдэглэжээ.

Хэвтээ дөрвөлжин бичгийн монгол хэлний дурсгал “Жавзандамбын цадиг” -т хори орчим үгэнд **ñ** үсэг илрэв. Голдуу **n** гийгүүлэгчийн дараа **i** эгшиг орсон үг, харьяалахын тийн ялгалын

³ Он нь тодорхойгүй.

‘-nu/ü’, заахын тийн ялгалын ‘-yi/-i’, гурван биед хамаатуулах ‘-ni’ дагавар бичихэд хэрэглэсэн байна. Жишээлбэл, ‘ñel-ka, ta-ñin, ñi-gen, ñi-yo-rong, tñ-ña, tö-ñi, te-gü-ñi, mung-ñi, ya-ba-lai-ña, çay-dor-ñi’ гэх мэт.

Вагиндра үсгийн одоогоор мэдэгдэж байгаа арван нэгэн дурсгалд **ñ**-тэй үг жараад буй. Голдуу **n** гийгүүлэгчийн дараа **i** эгшиг илэрсэн үг, ‘ñüdüng, ñirvan, ñūca, ñūxa, ñuur, eñēke, tañād’ гэх мэт үгэнд хэрэглэсэн байна. Бас харьяалахын тийн ялгалын ‘-nu/ü’, заахын тийн ялгалын ‘-i/yi*’, гурван биед хамаатуулах ‘-ni’ -д тус тус хэрэглэжээ. Жишээлбэл, ‘adūñi, kübūñi, burkañi, qañi, çayāñin, dūñin’ гэх мэт.

Дээрх хоёр үсгийн дурсгалд **ñ** тэмдэглэгдэж байгаа нөхцөл тохиолдол нь адил онцлогтой. Харьяалахын ‘-nu/ü’ ба заахын ‘-i/yi*’-г бүгдийг **ñi**-ээр тэмдэглэж буй. Үүний ялгааг зөвхөн үгийн орчноос магадлах боломжтой. ‘-ni’-г болохоор ‘**ñin**’ гэж дийлэнхдээ тэмдэглэж буй. Тухайн үсэг бичгүүд нь сайтар дүрэмжиж жигдрээгүй тул дагавар нөхцөлийг тэмдэглэсэн нь нэгдэлгүй байдал цөөнгүй харагдаж байна. Бид тэр бүхнийг хөөцөлдөлгүй, нийт баримжаагаар жишээ үгийг сонгов.

Жич, Монголд өргөн хэрэглэгдэж байсан төвөд үсгээр монгол хэлээр бичсэн дурсгалыг ажвал, Монгол улсын эрдэмтэн Р.Отгонбаатар, Оросын эрдэмтэн А.Д.Цендина нарын хамтарсан бүтээлд багтсан сүм хийдийн эд хогшлын дансанд “nyi thi ‘нийт’, bo gā nyi thor gon na bza’ ‘борооны торгон хувцас’, < kheng ge reg 3 nyi mo don ‘дөрвөн хэнгэрэг, гуравны модон’ ”(2014:167-168) гэхчлэн төвөдийн **nya** үсгээр монгол хэлний **n**-ийн тагнайшлыг тэмдэглэсэн харагдана. Бас саяхан судалгааны эргэлтэд орсон XIII-XIV зууны үеийн араб үсгээрх монгол хэлний “Фарханг-э Насири буюу хачин хэлний толь”-д “nyd^woⁿ ‘nidün’, n_yu^ww^wr^o ‘niyur’, n_yu^wγw ‘niruyū’, n_ygn ‘nigen’, nymg^aan ‘nimgen’ ” (2023:141,142,154,155) зэрэг үгэнд **ny/n_y**-аар тагнайшсан гийгүүлэгч **ñ**-г тэмдэглэжээ. Эдгээр нь монгол хэлэнд **ñ** хэлэгдэж байсан ба тэмдэглэгдсэнийг тод харуулж байгаа баримтууд болох юм.

5. Дүгнэлт

Гурван монгол бичигт **n, ng, ñ** гурван гийгүүлэгч үсгийг тэмдэглэсэн байдлыг харьцуулж судалсны дүнд доорх дүгнэлтийг хийж байна.

Нэгдүгээрт, **n, ng** хоёр гийгүүлэгчийг сольж хэрэглэж байсан нь ажиглагдав. Ялангуяа, **ng** гийгүүлэгч нь үгийн эцсийн **n** гийгүүлэгчийг орлож тэмдэглэсэн нь олонтоо тохиолдож буй. **ng** гийгүүлэгч үсэг нь монгол бичигт тийм идэвхтэй биш, гэхдээ авианы хөгжил хувиралтын нөлөөгөөр гурван монгол бичигт **n** төгсгөлтэй үгс **ng**-ээр бичигджээ. Үүний улмаас гурван монгол бичгийн үгсийн санд их хувиралтыг авчрав. Учир нь үгсийн сангийн хоёр том аймаг болох нэр үг ба үйл үгийн **n** төгсгөлтэй үгнүүд нь цөм **ng** гийгүүлэгчээр тэмдэглэгдэх болсон бөгөөд дээр нь бас тийн ялгалын нөхцөл нэмэхээр **ng** гийгүүлэгч нь гурван монгол бичигт үнэхээр цагаан толгойн жагсаалтад орохуйц авиа тэмдэглэгч болжээ. Хоёр гийгүүлэгчийн тэмдэглэгдсэн байдал нь монгол бичигт **n** төгсгөлтэй үгсийн эцсийн [n] гийгүүлэгч нь монгол хэлний халх, буриад аялгуунд маш идэвхтэй [ŋ] болж байгаа авианы хувиралтыг тодорхой тусгасан байна.

Хоёрдугаарт, Бусад монгол бичигт ерөөс тэмдэглэж байсангүй нэгэн онцлогтой **ñ** үсгийг гурван монгол бичгээр төдийгүй төвөд үсгээр монгол хэлийг тэмдэглэсэн дурсгалуудад ч тэмдэглэсэн байна. Тэр нь монгол хэлний үгийг тэмдэглэж буй. Ихэнхдээ **i** эгшгийн өмнөх **n** гийгүүлэгчийг тусгайлан тэмдэглэжээ. Гурван монгол бичиг нь энэтхэг төвөдийн үсгийн нөлөөгөөр **ñ** үсгийг авч тэмдэглэсэн байх талтайн боловч монгол хэлний халх, буриад аялгуунд тус авиалбар байсан ба авиалбарын тогтолцоонд байраа эзэлж эхэлснийг анзааран түүнийг тэмдэглэсэн тал оршино хэмээн үзэж байна. Нэн эртний араб үсгийн монгол хэлний дурсгалууд түүнийг анхаарч **n**-с ялган тэмдэглэж ч буй.

Гуравдугаарт, **ng, ñ** хоёр гийгүүлэгч үсэг нь гурван монгол бичигт нэг бүлэг тийн ялгалын нөхцөлийг тэмдэглэсэн онцлогтой. **ng** гийгүүлэгч нь харьяалахын тийн ялгалын ‘-yin, -un’,

ерөнхийлөн хамаатуулах ‘-ben/-iyen’, сул үг ‘müng’ зэрэг дагавар ба сул үгнүүдийн төгсгөлийн **п** гийгүүлэгчийг тэмдэглэж, **ñ** гийгүүлэгч нь гурван биед хамаатуулахын ‘-ni’, **п** төгсгөлтэй үгийн дараа илэрсэн харьяалах ба заахын тийн ялгалын дагаврыг тус тус тэмдэглэжээ.

Ном зүй

- Агваандорж.** (он нь тодорхойгүй) *Шинэ хуучин үсгүүдийн ялгал тэргүүтнийг бичсэн дэвтэр оршвой /гар бичмэл судар/*. [Agvaandorj. *Shine khuuchin üsgüüdiin yalgal tergüütniig bichsen devter orshvoi. /Gar bichmel sudar/* [A notebook containing the differences between the old and new scripts]. (Соёлмаа. 2017). *Вагиндара үсгийн сурвалж бичгийн судлал*. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо)-аас дам эшлэв.
- Агваанчүлтэмжамц.** (1925). *Найман богдын намтар*. судар.[Agvaanchüldemjamts. *Naiman bogdyn namtar. sudar* [Biography of the eight bogds].1925.] (Дарамбазар, Б.(2022). *Найман богдын намтар*. Улаанбаатар: Битпресс ХХК)-аас дам эшлэв.
- Анхбаяр, Д.** (2023). *Фарханг-э Насири буюу хачин хэлний толь*. Улаабаатар: Соёмбо Принтинг ХХК. [Ankhubayar, D. *Farkhang-e Nasiri buyu khachin khelnii toli* [FARHAG-E NASÎR-Î dictionary]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2023.]
- Лутжаргал, А.** (1991). Orčin čay-un mongyol kelen-ü [ŋ] abiyalaburi. *Mongyol kele bičig*. II : 30-38. [Lutjargal, A. The phoneme[ŋ] of modern Mongolian. *Mongol khel bichig*, Hohhot: 1991, II : 30-38.]
- Нямбуу, Х.** (2002). *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар:Адмон. [Nyambu, Kh. *Mongol khuvtsasny tüükh* [History of Mongolian clothing]. Ulaanbaatar: Admon. 2002.]
- Отгонбаатар,Р.** (2018). Соёмбо үсгийн содон бичлэгээс. *Шинжлэх ухаан амьдрал*. 6 сар. № 02 (349):32. [Otgonbaatar, R. From the classic recording of the Soyombo script. *Shinjelekhe ukhaan amidral*, Ulaanbaatar: 2018, 6 сар. № 02(349):32-36]
- Отгонбаатар, Р., Цендина, А. Д.** (2014). *Монгол үсэг бичгийн дээж*. Москва: Наука-Восточная литература. [Otgonbaatar, R.,Tsendina, A. D. *Mongol üseg bichgiin deej* [Examples of the written tradition of northern Mongolia].Ulaanbaatar: Nauka-Vostokchnaya. 2014.]
- Пэлжээ.** (1992). Mongyol barimjiy-a abiyau-u ‘ng’ geyigülügči-yin asayudal-du. *Mongyol kele bičig*. II: 30-43. [Peljee. On the issue of the ng consonant of the Mongolian dialect phoneme. *Mongol hel bichig*, Hohhot: 1992, II: 30-43.]